

**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/09

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл шинээр
олгох, сунгах, ажлын байрны
байршил өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.17, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2, 5 дугаар зүйлийн 5.5, Эрүүл мэндийн сайдын "Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам"-ын 2.6.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагын нэрсийг нэгдүгээр, үйл ажиллагаа явуулж буй ажлын байрны байршил өөрчилсөн байгууллагуудын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баян-Овоо суманд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн "Ивээлт Божной Фарм" ХХК-ийн эмийн сан, Дэлгэрхаан суманд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн "Нандин тан" ХХК-ийн эмийн сангуудын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатай олгосугай.

3. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга /Х.Доржханд/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга /Д.Наранмичид/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Л.МЭНДБАЯР


СНЭЭ0004 9073376